

Нэг.Удирдлага зохион байгуулалтын талаар

Дунд хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэлийг сайжруулах төлөвлөгөөний биелэлт, байгууллагын ил тод байдлын үнэлгээний тайлан ирүүлэх, засаглалын болон эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт газрын хэмжээнд нэгтгэж ХХААЯаманд хүргүүлээ.

Хэрэглэгчийн үнэлгээг “Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг” ТББ-ын Дархан дахь салбартай ажил гүйцэтгүүлэх гэрээг байгуулж ажиллалаа. Гэрээний дагуу 520 хэрэглэгчээс үнэлгээний маягтын дагуу судалгааг авсан байна. Үнэлгээгээр нийт оролцогчдын 240 хангалттай сайн, 180 дунд зэрэг, 40 хангалтгүй, 60 мэдэхгүй гэж хариулт өгсөн байна. Нийт судалгаанд оролцогчдын 79.6% нь дундаас дээш үнэлгээ өгсөн байна.

Тус газрын “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг 1 үе шаттай 14 зорилттойгоор боловсруулан, газрын даргын 2015 оны 69 тоот тушаалаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа

Тус газрын зүгээс гэмт хэрэг, зөрчил, архидан согтуурахтай тэмцэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажил зохион байгуулсан ажлын товч тайланг ХЗХэлтэс жилийн эцсийн байдлаар тайланг хүргүүлж ажиллалаа.

Байгууллагын соёл, зохион байгуулалт, үйл ажиллагааны нээлттэй байдлын талаархи сэтгэл ханамжийн судалгааг 20 асуулгатайгаар анх удаа цахим хэлбэрээр албан хаагчдаас авах ажлыг зохион байгууллаа.

Хоёр:Салбарын хүрээнд

Мал аж ахуй салбар:

Аймгийн Засаг даргын 2015 оны А/361 тоот захирамжийн дагуу Орхон, Дархан, Хонгор сумдад хяналт тавин ажиллалаа. Мөн Хонгор сумын Мал, тэжээвэр амьтдын тооллогыг Зулзага багийн малчин Л.Бат-Очирынхоос албан ёсоор эхэллээ. Л.Бат-очирынх Бух толгойн ард өвөлжиж байгаа бөгөөд нийт 1282 толгой буюу 70 толгой адуу, 130 толгой үхэр, 842 толгой хонь, 240 толгой ямаа тооллоо.

Мал эмнэлэг, үржлийн газрын даргын 2015 оны 01 тоот албан даалгаврын хэрэгжилтийн гаргаж хүргүүлээ.

Сумдын мал хээлтүүлгийн мэдээг маягтын дагуу нэгтгэн МЭҮГ-т хүргүүлсэн байна. Үүнд нийт хээлтэгч малын 82-90 хувь хээл авсан дүн мэдээтэй байна.

2015 оны 12 дугаар сарын 03-ны байдлаар Малын үндэсний бүртгэл мэдээллийн системийн хяналтын оффлайн, онлайн програмд 73 хувь буюу 40,8 мянган толгой малын бүртгэлээ.

2000 оноос хойш тус аймагт Улсын төсөв, орон нутгийн төсөв, сум хөгжүүлэх сан, гадаадын төсөл хөтөлбөрийн хүрээнд шинээр барьж байгуулах, сэргээн засварласан бэлчээрийн зориулалттай инженерийн хийцтэй худгуудын ашиглалтгүй байгаа худгийг орон нутгийн өмчлөлөөс чөлөөлөх тухай ХХААЯ-ны чиглэлийн дагуу аймгийн Засаг даргын 2015 оны А/335 дугаар захирамжаар худгийн тооллого хийх ажлын хэсэг томиллоо. Уг ажлын хэсэгт Аймгийн орон нутгийн өмчийн алба, Аудитын

газар, Хөгжлийн бодлогын хэлтэс, ХХААГазар, 4 сумын Засаг дарга нар томилогдон 4 сумын нийт 112 худаг хамруулсан байна. Мөн орон нутагт байгаа худгуудыг эзэмшүүлж, ажиллахгүй байгаа болон эдвэрсэн 13 худгуудын судалгааг нэгтгэн орон нутгийн өмчөөс чөлөөлөхөөр аймгийн Орон нутгийн өмчийн албанд саналаа хүргүүлсэн байна.

Мал эмнэлгийн салбар

2015 оны мал эмнэлгийн арга хэмжээний хэрэгжилтийн тайлан болон жилийн эцсийн мэдээг 24 маягтаар гарган МУ-ын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлэг, үржлийн газарт хүргүүлэв. ХХАА-н сайдын аймгийн Засаг дарга болон ХХААГ-ын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг заалт бүрээр гарган ХХААЯ болон аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлэв. “Монгол мал” Үндэсний хөтөлбөр, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр, ЗГ-ын тогтоол, шийдвэр, Үндэсний хэмжээний хөтөлбөр, төслүүд, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолын хэрэгжилт, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт зэрэг 10 гаруй тайланг цаг хугацаандаа гарган холбогдох хэлтэс, газаруудад хүргүүлэв.

Орон нутгийн мал эмнэлгийн нэгжүүдээс намрын тарилга, шинжилгээ хийсэн акт, баримтуудыг гаргуулан авч, хянан үзэж санхүүжилтийг нь олгуулахаар аймгийн төрийн санд уламжлаад байна. Төвийн бүсийн аймгуудыг шүлхий болон мялзан өвчнөөс эрүүлийг баталгаажуулах тандалт шинжилгээ хийсэн ажлын санхүүгийн тайланг гарган Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторид хүргүүлэн үлдэгдэл санхүүжилтийг нь авч холбогдох мэргэжилтнүүд болон аж ахуй нэгжүүдэд шилжүүллээ.

Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Байгаль орчны хамааралтай өвчнүүдийн оношлогоо, урьдчилан сэргийлэх арга замыг боловсронгуй болгох нь” сэдэвт эрдэм шинжилгээ, онол үйлдвэрлэлийн бага хуралд оролцож Дархан-Уул аймагт гарсан хромын хордлогын талаар мэдээлэл хийлээ.

Жилийн эцсийн мал тооллогын ажил эхлэхтэй холбогдуулан Орхон суманд мал тооллогын ажлын хэсгийн хуралд оролцон зарим анхаарах асуудлуудын талаар мэдээлэл өгч, хяналтын тоолоогоор тус суманд 3 хоног ажиллаж 30 орчим өрхөөр орж тооллого хийсэн байдалтай танилцан хяналтын тооллогоо хийлээ.

Газар тариалангийн салбар

Газар тариалангийн үйлдвэрлэлтийн жилийн эцсийн тайланг гарган ХХААЯ-нд хүргүүллээ. Энэхүү тайланд тусгагдсанаар буудай 3812.8 тонн хураан авч гурлын үйлдвэрүүдэд 2317.5 тонн, 339.6 тонн ТЭДСанд, 172.5 тонн улсын үрийн нөөцөд, 192.8 тонн тэжээлд, 203.7 тонн борлуулагдаагүй үлдсэн байна. Уринш боловсруулалтыг 12500 га хийхээр төлөвлөснөөс 48 аж ахуйн нэгж, 66 иргэн 12277.3 га-д хийсэн байна. 2016 оны хаврын тариалалтанд 1964.3 тонн үр шаардагдах бөгөөд 9 аж ахуйн нэгж, иргэн 560.7 тонн буюу нийт тариалах үрийн 28.5 хувийг нөөцөлж 1400 тонн үр дутагдах тооцоог гаргасан байна.

ХХААЯ, БНХАЯ-ын ХААЯам, НҮБайгууллагаас хамтран зохион байгуулагдсан “Хүлэмжинд хүнсний ногоо тариалах технологи, ургамал хамгаалал” сэдэвт сургалтыг хамтран зохион байгуулж Сэлэнгэ, Булган, Хөвсгөл, Эрдэнэт, Дархан-уул аймгийн 98 тариаланч оролцлоо.

Хүнсний үйлдвэрлэлийн салбар

ХХААЯам “Хүнсний аюулгүй байдал үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг гаргаж хүргүүлсэн байна. Аймгийн баталгаажуулалтын зөвлөлийн хуралд оролцсон байна.

Тайланг нэгтгэсэн: Архив, Бичиг хэргийн эрхлэгч Д.Ганбаяр

Тайланг хянасан: ЗУХэлтсийн дарга Б.Бат-Эрдэнэ

БАТЛАВ: ХХААГ-ЫН ДАРГА

Ц.ЭНХЖАРГАЛ

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН

**2015 ОНЫ 01 ДҮГЭЭР САРД ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Хийгдэх ажил	Огноо	Хариуцах эзэн	Хүрэх үр дүн
Захиргаа удирдлагын хэлтэс				
1	Төрийн захиргааны албан хаагчдын үр дүнгийн гэрээний биелэлтэд ХШҮ хийх.	Сардаа	Б.Бат-Эрдэнэ	Төрийн захиргааны албан хаагчдын ажил дүгнэгдсэн байна.
2	Жилийн эцсийн тайлангуудад ХШҮ хийх ажлыг зохион байгуулах.	Сардаа	ХШҮ-ний баг	ХШҮ-ний тайлангууд гарсан байна.
3	Хөдөө аж ахуйн нэгдсэн бодлого, Хөгжлийн цогц бодлогын тайлангуудыг ХБХ-т хүргүүлэх.	Сардаа	Б.Бат-Эрдэнэ	Тайлан хугацаандаа хүргэгдсэн байна.
4	Дотоод аудитын төлөвлөгөөний ажлуудыг зохион байгуулах.	Сардаа	Б.Бат-Эрдэнэ	Төсвийн ил тод байдал сайжирна.
Мал аж ахуйн хэлтэс				
5	Аймгийн мал тооллогод хяналт тавин ажиллах	Сардаа	МААХ	Дүн мэдээ үнэн зөв гарсан байна.
	Улсын сайн малчны материал сумдаас хүлээн авч нэгтгэх.			МУЗГ-ын 70 тогтоолын дагуу хугацаанд ХХААЯ-д хүргүүлсэн байна.
6	Малчдын 2015 оны сүүлийн хагас жилийн арьс, ширний урамшууллын материалыг Сумдаас хүлээн авах.			МУЗГ-ын 394 дүгээр тогтоолоор Сумдын МЭҮТ-ууд Цахим програмд оруулсан байна.
7	Мал үржлийн тайланг хүргүүлэх.			МЭҮГ-т хугацаанд нь хүргүүлсэн байна.
	Эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа фермерийн судалгааг Сумдаас авч нэгтгэх.			Судалгааг нэгтгэн ХХААЯ-д хугацаанд нь хүргүүлсэн байна.
	Малчдын 2014 оны арьс, ширний урамшууллыг Малчин дансаар олгож эхлэсэнтэй холбогдуулан МЭҮТ-тай хамтран хяналт тавьж ажиллах			4 сумын 652 малчинд урамшуулал олгосон байна.

Мал эмнэлгийн хэлтэс				
8	Орон нутгийн нэгжүүдийн намрын тарилгын материалыг бүрдүүлэн хянаж үзэх	12-р сарын 10-ны дотор	Мал эмнэлгийн хэлтэс	Тайланг хугацаандаа хүргүүлэх
9	Урьдчилан сэргийлэх тарилгын үйлчилгээний хөлсний үлдэгдэл санхүүжилтийг олгуулах	Сардаа		Тайланг хугацаандаа хүргүүлэх
10	Мал эмнэлгийн арга хэмжэний жилийн эцсийн мэдээ тайлан гаргах	Сардаа		Санхүүжилтийг олгосон байна.
11	Бруцеллёзын тарилга хийсэн үйлчилгээний хөлсний санхүүжилтийг олгох	Сардаа		Үндсэн баримт материалыг хянан үзсэн байна.
12	Үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг гаргах	Сардаа		Санхүүжилтийг шилжүүлэн авсан байна.
13	Орон нутгийн нэгжүүдтэй байгуулсан үр дүнгийн гэрээг дүгнэх	Сардаа		Хугацаандаа гаргасан байна.
Хүнс, газар тариалангийн хэлтэс				
14	Хэлтсийн сарын ажлын төлөвлөгөө тайланг батлуулах	сардаа	О.Нэмэхбат	Сарын төлөвлөгөөг батлуулсан.
15	Албан бичгүүдийг хариуг хугацаанд нь чанартай гаргаж холбогдох газарт хүргүүлэх	сардаа		Албан бичгүүдийн хариуг хугацаанд хүргэсэн байна.
	Газар тариалангийн үйлдвэрлэлийн суурь судалгаанд баяжилт хийх	сардаа	О.Нэмэхбат	Хугацаанд нь гаргаж хүргүүлэх
	Хүнсний авулгүй байдал аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг гаргах	сардаа	О.Нэмэхбат	Хугацаанд нь гаргаж хүргүүлэх

	Төлөвлөгөөнөөс гадуур зохион байгуулж байгаа болон бусад ажлуудад идэвхи санаачлагатай оролцох	12 сард	О.Нэмэхбат	
--	------------------------------------------------------------------------------------------------------------	---------	------------	--

Хүнс, хөдөө аж ахуйн газар